

## СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ

Азийн хөгжлийн банкны “Улсын эмнэлэгт боломжийн үнэтэй эмийн хангамж хүртээмжийг сайжруулах” техникийн туслалцааны (8967-МОН) төслийн хүрээнд зарим ерөнхий нэршлийн эмийн 2018 оны хэрэгцээг нэгтгэн, ерөнхий гэрээгээр туршилтын худалдан авалтыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Энэхүү туршилтаар урьдчилсан сонголт бүхий ерөнхий гэрээг Монгол улсын эрүүл мэндийн салбарт анх удаа хэрэгжүүлэх ба эмийн хэрэгцээг нэгтгэн худалдан авалтыг төвлөрүүлэн зохион байгуулах талаар дараах эрхзүйн баримт бичгүүд гарсан байна. Үүнд:

1. “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолд эм, эмнэлгийн хэрэгслийн төвлөрсөн худалдан авалтын тогтолцоог бий болгох замаар төсвийн хэмнэлт бий болгох;
2. Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2017 оны 22 дугаар тогтоолд эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуурын худалдан авалтыг улсын хэмжээнд зохион байгуулах;
3. Монгол Улсын Засгийн газар Олон улсын валютын сангийн хооронд 2017 оны 05 дугаар сарын 24-ны өдөр байгуулсан “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг нэгдсэн байдлаар зохион байгуулж, зардал хэмнэхээр тусгагдсан. Энэ хүрээнд нийт эмийн төсвийн 10 хувь буюу 9.1 тэрбум төгрөгөөс хэтрүүлэхгүйгээр эмийн худалдан авалтыг хийхээр Сангийн яамны тооцооллод тусгасан;
4. Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй хэрэгжиж буй “Улсын эмнэлгүүдийн боломжит үнийн эмийн хүртээмжийг сайжруулах” техникийн туслалцааны төслийн хүрээнд ерөнхий нэршлийн 10 нэрийн эмийн хэрэгцээг нэгтгэн ерөнхий гэрээний дагуу туршилтын худалдан авалтыг зохион байгуулахаар төслийн баримт бичигт тусгасан.
5. “Журам батлах тухай” Сангийн сайдын 2017 оны 234 дүгээр тушаалаар Ерөнхий гэрээ байгуулах журам батлагдсан.

ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу олон улсын эм худалдан авах ажиллагааны зохистой дадлын шаардлагад нийцүүлэн, эмийн зохицуулалт бүрэн бэхжээгүй орнууд бүтээгдэхүүн ба нийлүүлэгчийн урьдчилсан сонголтыг хэрэглэдэг зарчмыг баримталж байна.<sup>1</sup>

Эрүүл Мэндийн Яам(ЭМЯ)-аас хэрэгцээг нэгтгэн, урьдчилсан сонголт бүхий ерөнхий гэрээгээр эм худалдан авах туршилтыг 2017 онд багтаан, хоёр ба гуравдугаар шатлалын эмнэлгүүдийг хамруулан зохион байгуулах шийдвэр гаргасан.

Сангийн Сайдын баталсан ерөнхий гэрээний журмаар<sup>2</sup> мэргэжлийн байгууллага (Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар- ТӨБЗГ) нь ерөнхий гэрээнд хамруулах бараа, үйлчилгээг зах зээлийн судалгаанд үндэслэн тодорхойлохоор зохицуулсан байдаг.

**Зах зээлийн судалгааны ажлын зорилго:** Сонгогдсон 29 нэрийн эмийн 2018 оны хэрэгцээг улсын эмнэлгүүдийн 2016, 2017 оны тендерийн тайлан, мэдээнд дүн шинжилгээ хийж бодит тоо, техникийн тодорхойлолт гаргахад оршино.

### Судалгааны ажлын зорилгууд:

1. Эрэлтийн судалгаа
2. Оролцогч талуудын судалгаа
3. Зах зээлийн судалгаа
4. Тухайн барааг ерөнхий гэрээгээр авахад үүсэх нөхцлийг тодорхойлох SWOT шинжилгээ хийх
5. Ерөнхий гэрээтэй холбоотой эрсдлүүдийг тодорхойлох, эрсдлээс сэргийлэх төлөвлөгөө гаргах

**Хамрах хүрээ:** Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэшлийн төвүүд

<sup>1</sup> The World Bank also recommends prequalification of products and suppliers. International organisations as UNICEF and UNFPA routinely use prequalification in their tendering processes.

<sup>2</sup> Сангийн Сайдын 2017 оны 7 сарын 4-ны өдрийн 234 тоот тушаалаар баталсан “Ерөнхий гэрээ байгуулах журам

## СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2018 оны ерөнхий гэрээгээр худалдан авах 29 нэрийн эмийн хэрэгцээг тодорхойлсон тайлан, техникийн тодорхойлолт гарна.

Сангийн сайдын 2017 оны “Журам батлах тухай” 234 дүгээр тушаалаар Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, үйлчилгээний судалгааны маягтыг баталсан. 29 нэрийн эмийн зах зээлийн судалгааг энэхүү маягтын дагуу боловсруулав.

### 1. Эрэлтийн судалгаа

1.1. Нийт худалдан авалт буюу нийт эрэлт хэрэгцээг тодорхойлж, түүний ач холбогдлыг үнэлэх.

1.2. Дээрх эрэлт хэрэгцээтэй уялдуулан нийлүүлэлтийн талаар судалгаа хийж, үүсч болзошгүй хүндрэл, бэрхшээлийг тооцох

1.3. Ерөнхий гэрээнд хамруулах бараа, үйлчилгээний нэр, танилцуулга, техникийн тодорхойлолтыг гаргах

1.1. Нийт худалдан авалт буюу нийт эрэлт хэрэгцээ, түүний ач холбогдлын үнэлгээ

Сонгогдсон 29 нэрийн эмийн эрэлт хэрэгцээг улсын эмнэлгүүдийн 2016, 2017 оны тендерийн тайлан, мэдээллийг нэгтгэн гаргасан. Хүснэгт 1.

2016 онд энэхүү 29 нэрийн эмийн эрэлт нь 7,024,991,188 төгрөг хүрсэн бөгөөд 2017 онд энэ нь 1,317,908,029 төгрөгөөр нэмэгдсэн байна. Иймээс ерөнхий гэрээгээр 2018 онд худалдан авах энэ 29 нэрийн эмийн хэрэгцээ нь нэмэгдэх хандлагатай байна.

Хүснэгт 1. 29 эмийн 2016, 2017 онд тендерээр нийлүүлсэн тоо хэмжээ, нэгжийн үнэ, үнийн дүн

№	Эмийн нэр	Тун, хэмжээ	Эмийн хэлбэр	2016			2017		
				Тоо хэмжээ	Медиан үнэ, ₮	Үнийн дүн, ₮	Тоо хэмжээ	Медиан үнэ, ₮	Үнийн дүн, ₮
1	Амлодипин түүний давсууд	10мг	бүрхүүлтэй шахмал	267,275	354	94,591,295	338,944	578	195,929,969
2	Амлодипин түүний давсууд	5мг	бүрхүүлтэй шахмал	126,203	237	29,913,897	139,636	169	23,598,484
3	Амоксициллин+клавуланы хүчил	500мг + 125мг	бүрхүүлтэй шахмал, капсул	76,456	1,431	109,377,954	95,395	990	94,456,313
4	Атракриум	25мг-2.5мл	тарилгын уусмал	39,730	5,317	211,250,370	37,646	7,277	273,954,083
5	Бупивикайн гидрохлорид	20мг - 4 мл	тарилгын уусмал	44,072	4,397	193,773,566	38,395	4,520	173,560,374
6	Гемофилийн эсрэг VIII фактор	500 ОУН	тарилгын уусмал	2,062	508,388	1,048,295,252	3,153	337,677	1,064,694,200
7	Гемофилийн эсрэг VIII фактор	250 ОУН	тарилгын уусмал	802	208,678	167,359,997	815	218,864	178,374,000
8	Гемофилийн эсрэг IX фактор	500 ОУН	тарилгын уусмал	849	455,114	386,391,973	1,203	687,312	826,836,520
9	Гемофилийн эсрэг IX фактор	250 ОУН	тарилгын уусмал	-	-	-	-	-	-
10	Гемофилийн эсрэг VIII, Виллебрандын холимог	500 ОУН	тарилгын уусмал	-	-	-	-	-	-

	фактор								
11	Гликлазид	80 мг	шахмал	486,621	156	75,820,418	519,730	227	118,077,459
12	Декстроз	5%- 200мл, 250мл	тарилгын шингэн	43,000	1,648	70,870,880	50,237	1,779	89,382,675
13	Диклофенак түүний давсууд	75мг- 3мл	тарилгын уусмал	93,002	626	58,210,882	130,116	757	98,475,692
14	Диклофенак түүний давсууд	100мг	шулуун гэдэсний лаа	197,550	464	91,619,739	262,234	491	128,798,851
15	Ибупрофен	400мг	бүрхүүлтэ й шахмал, капсул	883,105	69	60,828,272	967,399	74	72,003,508
16	Инсулин богино	100 мг - 3мл	тарилгын уусмал	25,642	11,065	283,732,063	26,615	12,872	342,596,265
17	Инсулин урт	100 мг - 3мл	тарилгын уусмал	49,013	9,729	476,839,145	43,664	11,743	512,764,254
18	Клопидогрел	75мг	бүрхүүлтэ й шахмал	91,198	773	70,499,702	109,008	920	100,247,027
19	Лизиноприл дигидрат	10мг	шахмал, бүрхүүлтэ й шахмал	141,647	411	58,151,759	175,579	487	85,515,752
20	Лозартан түүний давсууд	50мг	бүрхүүлтэ й шахмал, капсул	115,515	254	29,395,102	106,508	373	39,727,484
21	Метоклопра мид	50мг/м л - 2мл	тарилгын уусмал	164,581	655	107,828,534	220,479	747	164,766,823
22	Натри хлорид	0.9% - 200мл, 250мл	тарилгын шингэн	754,503	1,358	1,024,660,344	815,582	1,277	1,041,180,137
23	Натри хлорид	0.9% - 100мл	тарилгын шингэн	684,561	1,574	1,077,608,544	690,746	1,432	988,968,678
24	Пантопразол	20мг	бүрхүүлтэ й шахмал, капсул	198,775	294	58,493,519	215,144	363	78,052,092
25	Рингер лактат /Натрийн хлорид +Калийн хлорид+Кал цийн хлорид+ Натрийн лактат /	400мл, 500мл	тарилгын шингэн	169,954	2,483	422,068,862	212,118	2,662	564,668,722
26	Севофлуран	250 мл	ингаляци йн уусмал	812	203,520	165,257,899	1,766	195,642	345,504,355
27	Спиринолак тон	25мг	бүрхүүлтэ й шахмал, капсул	387,197	276	106,750,213	359,150	296	106,193,472
28	Сурфактант	120мг	хөвмөл, нунтаг	252	1,227,800	309,405,600	319	1,161,013	370,363,252
29	Цефтриаксо н	1 гр	тарилгын нунтаг	216,786	1,089	235,995,407	238,574	1,107	264,208,776
	<b>НИЙТ</b>					<b>7,024,991,188</b>			<b>8,342,899,217</b>

1.2. Дээрх эрэлт хэрэгцээтэй уялдуулан нийлүүлэлтийн талаар судалгаа хийж, үүсч болзошгүй хүндрэл, бэрхшээлийг тооцох

Туршилтанд хамруулах эмийг сонгох шалгуурыг Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/202 дугаар тушаалаар байгуулагдсан эмийн худалдан авалтын дэд ажлын хэсэг болон эмнэлэгүүдийн эм зүйч нарыг оролцуулсан өргөтгөсөн хурлаар удаа дараалан хэлэлцэж, Удирдлагын зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлсэн. Эмийг сонгох шалгуур нь:

- Ерөнхий нэршлийн эм байх
- Жилийн нийлүүлэлт өндөр байх /50 сая төгрөгөөс дээш/
- Зайлшгүй шаардлагатай эм байх
- Нийтлэг хэрэглэдэг байх /18 дээш эмнэлэгт хэрэглэдэг/
- Нийлүүлэгч олон байх /3 дээш/
- Олон улсын жишиг үнэтэй харьцуулахад хэмнэлт гаргах боломжтой байх /Медиан үнийн харьцаа 2 ба түүнээс дээш/
- Тасалдалын эрсдэлийг тооцох /өөр эмээр орлуулах боломжтой, өөр савлагаатайгаар байдаг/

Ерөнхий гэрээгээр худалдан авах эм сонгох явцад дээрх боловсруулсан 7 шалгуурт нийцээгүй зайлшгүй шаардлагатай 3 нэрийн эмийг эмнэлгүүдийн санал болгосноор оруулсан. Үүнд:

- Севофлуран 250мл /гаж нөлөө багатай амьсгалаар хэрэглэх ерөнхий мэдээгүйжүүлэх бэлдмэл. Үнийн хувьд өндөр байдаг тул бага үнэтэй изофлураныг хэрэглэж байна/
- Атракриум /гаж нөлөө багатай булчин сулруулах бэлдмэл, эмийн худалдан авалтын явцад нийлүүлэх компаний тоо хязгаарлагдмал/
- Пантопризол 20мг /бүх эмнэлгийн эмчилгээнд байнга хэрэглэгддэг/

ЭМЯ-ны саналаар гемофилийн эсрэг VIII, IX фактор, сурфактантыг нэмэлтээр эмийн жагсаалтад оруулсан болно.

Севофлуран 250мл, атракриум, гемофилийн эсрэг VIII, IX фактор, сурфактантын ханган нийлүүлэгчийн тоо цөөн байгаа нь тодорхой хүндрэл учруулж болзошгүй юм.

1.3. Ерөнхий гэрээнд хамруулах бараа, үйлчилгээний нэр, танилцуулга, техникийн тодорхойлолтыг гаргах

Сонгогдсон эмийн техникийн шаардлагыг олон улсын стандартын дагуу дараах хэвлэлийг ашиглан боловсруулсан болно. Үүнд:

- Британий Фармакопей болон Нэгдсэн Улсын Фармакопей
- Мартиндаль: Бүрэн хэмжээний эмийн лавлах.<sup>3</sup> Энэхүү хэвлэлд 43 улсад бүртгэгдсэн бүтээгдэхүүний жагсаалтыг багтаасан байдаг.

Бүтээгдэхүүний техникийн шаардлага боловсруулахад брэнд нэршил ашигладаггүй тул тэдгээрийг ерөнхий нэршил буюу олон улсын ашгийн бус нэршилээр тодорхойлсон болно. Бүтээгдэхүүн нь эмнэлгийн савлалттайгаар үйлдвэрлэгддэг тохиолдолд эмнэлгийн савлалтын хэмжээг сонгосон болно. Хүснэгт 2.

**Чанарын нийтлэг шаардлага:** Бүтээгдэхүүн бүр нь энэхүү техникийн тодорхойлолт болон Ерөнхий гэрээний дагуу худалдан авах эрүүл мэндийн салбарын барааны нийлүүлэгч-бүтээгдэхүүний урьдчилсан сонголтын баримт бичигт заасан чанарын шаардлагыг хангасан байна.

<sup>3</sup> 'Мартиндаль': Бүрэн хэмжээний эмийн лавлах нь дэлхий даяар хэрэглэж буй эмүүдийн талаар сайтар үнэлсэн, үнэн зөв мэдээллээр хангадаг. Энэхүү лавлахыг эм зүйчид, байгалийн шинжлэлийн эрдэмтдийн туршлагатай багаас бэлтгэдэг бөгөөд тэд өөрсдийн мэргэшил мэдлэгт тулгуурлан, эмнэлзүйн хамгийн их ач холбогдолтой, тохиромжтой мэдээллийг найдвартай хэвлэлийн эх сурвалжаас сонгон авч, үнэн зөв сайтар үнэлсэн ном зүйн товхимол болгон гаргадаг. Илүү дэлгэрэнгүйг дараах цахим хуудаснаас авна уу: [http://www.pharmpress.com/product/9780857113092/martindale39?utm\\_source=php\\_ealert\\_june&utm\\_medium=email&utm\\_campaign=ealert\\_list](http://www.pharmpress.com/product/9780857113092/martindale39?utm_source=php_ealert_june&utm_medium=email&utm_campaign=ealert_list); 2017 оны 7 сарын 6 өдөр нэвтэрсэн.

Хүснэгт 2. Техникийн тодорхойлолт

№	Эмийн нэр	Тун, хэмжээ	Эмийн хэлбэр	Савлалтын хэлбэр	Тусгай шаардлага	Техникийн үзүүлэлт
<i>Багц 1</i>						
1	Амлодипин түүний давсууд	10мг	бүрхүүлтэй шахмал	№10-100 хүртэл ширхэгтэй	-	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.
<i>Багц 2</i>						
2	Амлодипин түүний давсууд	5мг	бүрхүүлтэй шахмал	№10-100 хүртэл ширхэгтэй	-	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.
<i>Багц 3</i>						
3	Амоксициллин + клавуланы хүчил	500мг+ 125мг	бүрхүүлтэй шахмал, капсул	№10-100 хүртэл ширхэгтэй	-	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.
<i>Багц 4</i>						
4	Атракриум	25мг- 2.5мл	тарилгын уусмал	туншил	-	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.
<i>Багц 5</i>						
5	Бупивикайн гидрохлорид	20мг - 4 мл	тарилгын уусмал	туншил	гипертоник уусмал	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.
<i>Багц 6</i>						

6	Гемофилийн эсрэг VIII фактор	500 ОУН	тарилгын уусмал	флакон	Цусны бүлэгнэлтийн фактор VIII, (рекомбинант ДНХ), 500ОУН нунтаг, флакон + тариурт урьдчилан дүүргэсэн тарианы ус + холбогч (ариутгасан) + эрвээхий зүү + спирттэй сальфетка 2ш	<ul style="list-style-type: none"> <li>• Рекомбинант аргаар гарган авсан, өндөр цэвэршилттэй</li> <li>• Хүн, амьтны бүтээгдэхүүн агуулаагүй (халдвар дамжих эрсдлээс хамгаалах)</li> <li>• Альбумингүй (уураг агуулаагүй)</li> <li>• Цэвэршүүлэлтийн процесст олон үе шаттай хроматографи ба нанофилтраци хэрэглэсэн</li> <li>• Факторын хадгалалтын нөхцөл: 20- 30 хэм буюу тасалгааны хэмд хадгалах боломжтой (IX фактор)</li> <li>• ДЭМБ-ын олон улсын эмийн худалдааны сертификатын схем дэх Эмийн бүтээгдэхүүний сертификаттай эсхүл үйлдвэрлэгч нь “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын шаардлагыг хангасныг нотлох эрх бүхий байгууллагын сертификаттай байх</li> <li>• Америкийн Нэгдсэн Улсын ХЭА (FDA) эсхүл Европын холбооны эрх бүхий байгууллагын чанарын сертификаттай байх</li> <li>• Нийлүүлэлтийн давтамж: 2 удаа</li> <li>• Нийлүүлэх үеийн хүчинтэй хугацаа: Дуусах огноо 2 жилээс доошгүй</li> </ul>
<i>Багц 7</i>						
7	Гемофилийн эсрэг VIII фактор	250 ОУН	тарилгын уусмал	флакон	Цусны бүлэгнэлтийн фактор VIII, (рекомбинант ДНХ), 250 ОУН нунтаг, флакон + тариурт урьдчилан дүүргэсэн тарианы ус + холбогч (ариутгасан) + эрвээхий зүү + спирттэй сальфетка 2ш + шархны лент 1ш	<ul style="list-style-type: none"> <li>• Рекомбинант аргаар гарган авсан, өндөр цэвэршилттэй</li> <li>• Хүн, амьтны бүтээгдэхүүн агуулаагүй (халдвар дамжих эрсдлээс хамгаалах)</li> <li>• Альбумингүй (уураг агуулаагүй)</li> <li>• Цэвэршүүлэлтийн процесст олон үе шаттай хроматографи ба нанофилтраци хэрэглэсэн</li> <li>• Факторын хадгалалтын нөхцөл: 20- 30 хэм буюу тасалгааны хэмд хадгалах боломжтой (IX фактор)</li> <li>• ДЭМБ-ын олон улсын эмийн худалдааны сертификатын схем дэх Эмийн бүтээгдэхүүний сертификаттай эсхүл үйлдвэрлэгч нь “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын шаардлагыг хангасныг нотлох эрх бүхий байгууллагын сертификаттай байх</li> <li>• Америкийн Нэгдсэн Улсын ХЭА (FDA) эсхүл Европын холбооны эрх бүхий байгууллагын чанарын сертификаттай байх</li> <li>• Нийлүүлэлтийн давтамж: 2 удаа</li> <li>• Нийлүүлэх үеийн хүчинтэй хугацаа: Дуусах огноо 2 жилээс доошгүй</li> </ul>
<i>Багц 8</i>						
8	Гемофилийн эсрэг IX фактор	500 ОУН	тарилгын уусмал	флакон	Цусны бүлэгнэлтийн фактор IX,	<ul style="list-style-type: none"> <li>• Рекомбинант аргаар гарган авсан, өндөр цэвэршилттэй</li> <li>• Хүн, амьтны бүтээгдэхүүн агуулаагүй (халдвар дамжих</li> </ul>

					рекомбина нт ДНХ), 500 ОУН нунтаг, флакон + 10мл тарианы ус, флакон, холбогч (ариутгасан ) + тариур 10мл + эрвээхий зүү + спирттэй сальфетка 2ш + шархны лент 1ш	эрсдлээс хамгаалах) • Альбумингүй (уураг агуулаагүй) • Цэвэршүүлэлтийн процесст олон үе шаттай хроматографи ба нанофилтраци хэрэглэсэн • Факторын хадгалалтын нөхцөл: 20- 30 хэм буюу тасалгааны хэмд хадгалах боломжтой (IX фактор) • ДЭМБ-ын олон улсын эмийн худалдааны сертификатын схем дэх Эмийн бүтээгдэхүүний сертификаттай эсхүл үйлдвэрлэгч нь “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын шаардлагыг хангасныг нотлох эрх бүхий байгууллагын сертификаттай байх • Америкийн Нэгдсэн Улсын ХЭА (FDA) эсхүл Европын холбооны эрх бүхий байгууллагын чанарын сертификаттай байх • Нийлүүлэлтийн давтамж: 2 удаа • Нийлүүлэх үеийн хүчинтэй хугацаа: Дуусах огноо 2 жилээс доошгүй
<b>Багц 9</b>						
<b>9</b>	Гемофилийн эсрэг IX фактор	250 ОУН	тарилгын уусмал	флакон	Цусны бүлэгнэлтийн фактор IX, рекомбина нт ДНХ), 250 ОУН нунтаг, флакон + 10мл тарианы ус, флакон, холбогч (ариутгасан) + тариур 10мл + эрвээхий зүү + спирттэй сальфетка 2ш + шархны лент 1ш	• Рекомбинант аргаар гарган авсан, өндөр цэвэршилттэй • Хүн, амьтны бүтээгдэхүүн агуулаагүй (халдвар дамжих эрсдлээс хамгаалах) • Альбумингүй (уураг агуулаагүй) • Цэвэршүүлэлтийн процесст олон үе шаттай хроматографи ба нанофилтраци хэрэглэсэн • Факторын хадгалалтын нөхцөл: 20- 30 хэм буюу тасалгааны хэмд хадгалах боломжтой (IX фактор) • ДЭМБ-ын олон улсын эмийн худалдааны сертификатын схем дэх Эмийн бүтээгдэхүүний сертификаттай эсхүл үйлдвэрлэгч нь “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын шаардлагыг хангасныг нотлох эрх бүхий байгууллагын сертификаттай байх • Америкийн Нэгдсэн Улсын ХЭА (FDA) эсхүл Европын холбооны эрх бүхий байгууллагын чанарын сертификаттай байх • Нийлүүлэлтийн давтамж: 2 удаа • Нийлүүлэх үеийн хүчинтэй хугацаа: Дуусах огноо 2 жилээс доошгүй
<b>Багц 10</b>						



10	Гемофилийн эсрэг VIII, Виллебрандын холимог фактор	500 ОУН	тарилгын уусмал	флакон	Цусны бүлэгнэлтийн фактор VIII, (рекомбинант ДНХ) 500ОУН, (рекомбинант ДНХ), + Вилебрандын фактор 500ОУН 1:1 нийлмэл нунтаг, флакон + 10мл тарианы ус, флакон, холбогч (ариутгасан) + тариур 10мл + эрвээхий зүү + спирттэй сальфетка 2ш + шархны лент 1ш	<ul style="list-style-type: none"> <li>• Рекомбинант аргаар гарган авсан, өндөр цэвэршилттэй</li> <li>• Хүн, амьтны бүтээгдэхүүн агуулаагүй (халдвар дамжих эрсдлээс хамгаалах)</li> <li>• Альбумингүй (уураг агуулаагүй)</li> <li>• Цэвэршүүлэлтийн процесст олон үе шаттай хроматографи ба нанофилтраци хэрэглэсэн</li> <li>• Факторын хадгалалтын нөхцөл: 20- 30 хэм буюу тасалгааны хэмд хадгалах боломжтой (IX фактор)</li> <li>• ДЭМБ-ын олон улсын эмийн худалдааны сертификатын схем дэх Эмийн бүтээгдэхүүний сертификаттай эсхүл үйлдвэрлэгч нь “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын шаардлагыг хангасныг нотлох эрх бүхий байгууллагын сертификаттай байх</li> <li>• Америкийн Нэгдсэн Улсын ХЭА (FDA) эсхүл Европын холбооны эрх бүхий байгууллагын чанарын сертификаттай байх</li> <li>• Нийлүүлэлтийн давтамж: 2 удаа</li> <li>• Нийлүүлэх үеийн хүчинтэй хугацаа: Дуусах огноо 2 жилээс доошгүй</li> </ul>
<i>Багц 11</i>						
11	Гликлазид	80 мг	шахмал	№10-100 хүртэл ширхэгтэй	-	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.
<i>Багц 12</i>						
12	Декстроз	5%-200мл, 250мл	тарилгын шингэн	PVC агуулсан болон PVC агуулаагүй	давхар савлалттай	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.
<i>Багц 13</i>						
13	Диклофенак түүний давсууд	75мг-3мл	тарилгын уусмал	туншил	-	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.



Багц 14						
14	Диклофенак түүний давсууд	100мг	шулуун гэдэсний лаа	№5-10 хүртэл ширхэгтэй	-	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.
Багц 15						
15	Ибупрофен	400мг	бүрхүүлтэй шахмал, капсул	№10-500 хүртэл ширхэгтэй	-	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.
Багц 16						
16	Инсулин богино	100 мг - 3мл	тарилгын уусмал	туншил	Инсулин (хүний инсулин), тариа, 100ОУН/мл тарианы уусмал, 3мл картридж	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.
Багц 17						
17	Инсулин урт	100 мг - 3мл	тарилгын уусмал	туншил	Инсулин изофан (хүний инсулин, рекомбинант ДНХ), 100ОУН/мл тарианы уусмал, 3мл картридж	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.
Багц 18						
18	Клопидогрел	75мг	бүрхүүлтэй шахмал	№10-100 хүртэл ширхэгтэй	-	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.
Багц 19						
19	Лизиноприл дигидрат	10мг	шахмал, бүрхүүлтэй шахмал	№10-100 хүртэл ширхэгтэй	-	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн

						шаардлага хангасан.
<i>Багц 20</i>						
20	Лозартан түүний давсууд	50мг	бүрхүүлтэй шахмал, капсул	№10-100 хүртэл ширхэгтэй	-	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.
<i>Багц 21</i>						
21	Метоклопрамид	50мг/мл - 2мл	тарилгын уусмал	туншил	-	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.
<i>Багц 22</i>						
22	Натри хлорид	0.9% - 200мл, 250мл	тарилгын шингэн	PVC агуулсан болон PVC агуулаагүй	давхар савлалттай	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.
<i>Багц 23</i>						
23	Натри хлорид	0.9% - 100мл	тарилгын шингэн	PVC агуулсан болон PVC агуулаагүй	давхар савлалттай	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.
<i>Багц 24</i>						
24	Пантопразол	20мг	бүрхүүлтэй шахмал, капсул	№10-100 хүртэл ширхэгтэй	-	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.
<i>Багц 25</i>						
25	Рингер лактат /Натрийн хлорид +Калийн	400мл, 500мл	тарилгын шингэн	PVC агуулсан болон PVC агуулаагүй	давхар савлалттай	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт

	хлорид+Кальцийн хлорид+Натрийн н лактат/					үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.
<i>Багц 26</i>						
26	Севофлуран	250 мл	ингаляцийн н уусмал	флакон	-	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.
<i>Багц 27</i>						
27	Спиринолактон	25мг	бүрхүүлтэй шахмал, капсул	№10-100 хүртэл ширхэгтэй	-	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.
<i>Багц 28</i>						
28	Сурфактант	120мг	хөвмөл, нунтаг	флакон	Сурфактант (гахайн уушгинаас гарган авсан), 8% жин/ээл мөгөөрсөн хоолойд хэрэглэх хөвмөл, 1.5мл, флакон	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.
<i>Багц 29</i>						
29	Цефтриаксон	1 гр	тарилгын нунтаг	флакон	-	Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP-/ын шаардлага хангасан үйлдвэрт үйлдвэрлэсэн. Хүний эмийн үндэсний, ОХУ, Их Британи, АНУ, Япон, БНХАУ, Европын болон Олон улсын фармакопейн шаардлага хангасан.

2. Оролцогч талуудын судалгаа

- 2.1. Захиалагч бүрийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох
- 2.2. Нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн чадавхийг тодорхойлох

2.1. Захиалагч бүрийн хэрэгцээ, шаардлага

Эрүүл мэндийн салбарын 31 нэгжийн (үүнд: аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэшлийн төвүүд) эм зүйн алба нь 29 нэрийн эмийн 2018 оны хэрэгцээг тодорхойлон, Эмийн эмчилгээний хороогоороо хэлэлцүүлэн, албан бичгээр ирүүлснийг нэгтгэж Хавсралт 1-ээр гаргав.

Сонгогдсон 29 нэрийн эмийн хэрэгцээний нэгтгэлийг харахад ихэнх эмийн хувьд 2016, 2017 оны хэрэглээ Севофлуран эмээс бусад тохиолдолд ойролцоо байна. Севофлуран нь өмнөх үеийн Изофлуранаас гаж нөлөө багатай тул эмчилгээний практикт түлхүү хэрэглэх болсон.

Харин дараах 5 эмийн хувьд 2018 оны хэрэгцээ нь 2017 оны хэрэглээнээс илэрхий өссөн байна. Үүнд:

1. Амлодидин (бесилат, малеат эсвэл месилат), 5мг бүрхүүлтэй шахмал: 2.2 дахин
2. Амоксициллин+ клавуланы хүчил, 625мг бүрхүүлтэй шахмал, капсул: 2.3 дахин
3. Гликлазид, шахмал, 80мг шахмал: 2 дахин
4. Диклофенак түүний давсууд, 75мг-3мл тарилгын уусмал: 2.3 дахин
5. Клопидогрел бүрхүүлтэй 75мг бүрхүүлтэй шахмал: 2.6 дахин

Гемофилийн эсрэг факторуудын хувьд эмчилгээ нь хувь хүний онцлогоос шууд хамааралтай тул хэрэглээ нь жил жилээр өөрчлөгдөж байдаг. Иймд тухайн чиглэлээр мэргэшсэн эмнэлгээс гарган өгсөн хэрэгцээг шууд авсан болно.

2.2. Нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн чадавхийг тодорхойлох

2.2.1. Нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн чадавхи (дотоод)

Сонгогдсон 29 эмийн Монгол улсад бүртгэгдсэн байдал, 2016 оны импорт, дотоодын үйлдвэрлэлийн тоо хэмжээ болон тендэрээр худалдан авсан тоо хэмжээг Хүснэгт 3-д харууллаа. Нийт хангамжийн тоо мэдээг эмийн бүртгэл, импортын лиценз, тусгай зөвшөөрлийн LICEMED програмаас татан авсан болно. Хүснэгтээс харахад нийлүүлэлтийн нийт тоо хэмжээ нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авсан тоо хэмжээнээс их байгаа нь сонгогдсон эмийг нийлүүлэх дотоодын хүчин чадал хангалттай байна гэсэн дүгнэлтэд хүрч байна. Гэхдээ Монгол улсад бүртгэгдсэн байдлын хувьд дараах эмүүд 3-с цөөн улсаас бүртгэлтэй байна. Үүнд:

1. Лизиноприл дигидрат, 10мг шахмал, бүрхүүлтэй шахмал эм 2 улсаас бүртгэгдсэн.
2. Атракриум бесилат, 1% жин/эзэл тарианы уусмал, 2.5мл туншил 1 улсаас бүртгэгдсэн
3. Сурфактант (гахайн уушгинаас гарган авсан), 8% жин/эзэл мөгөөрсөн хоолойд хэрэглэх хөвмөл, 1.5мл, флакон 1 улсаас бүртгэгдсэн
4. Гемофилийн эсрэг факторуудын хувьд эдгээр нь өнчин эмийн жагсаалтад багтсан тул Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиар заавал бүртгүүлэх шаардлага тавигдаагүй.

Зарим нэг эмийн Монгол улсад бүртгэгдсэн тоо цөөн байгаа нь худалдан авах ажиллагаанд эрсдэл болохгүй, учир нь эрсдлээс сэргийлэх арга хэмжээ болгон эмийн түргэвчилсэн бүртгэлийг ашиглах боломжтой.

Хүснэгт 3. Бүртгэгдсэн болон импортлогдсон байдал, 2016

№	Тодорхойлолт (эмийн нэр, тун, эмийн хэлбэр, эмийн хэлбэрийн хамгийн бага нэгж)	Монгол улсад бүртгэгдсэн тоо	LICEMED системээс татаж авсан 2016 оны дотоодын нийлүүлэлтийн судалгаа	
			Нийт хангамж (дотоодод үйлдвэрлэсэн, импортлогсон тоо хэмжээ)	Тендэрээр худалдан авсан тоо хэмжээ
1	Амлодидин (бесилат, малеат эсвэл месилат), 10мг бүрхүүлтэй шахмал	16	8,859,960	267,275
2	Амлодидин (бесилат, малеат эсвэл месилат), 5мг бүрхүүлтэй шахмал	19	3,580,380	126,203
3	Амоксициллин (тригидрат) + Клавуланы хүчил (калийн давс), 500мг + 125мг бүрхүүлтэй шахмал, капсул	15	1,165,416	76,456
4	Атракриум бесилат, 1% жин/эзэл тарианы уусмал, 2.5мл туншил	1	46,000	39,730

5	Бупивакайн гидрохлорид, 0.5% жин/эзэл тарианы уусмал, 4мл туншил, флакон	4	66,321	44,072
6	Гемофилийн эсрэг фактор VIII, (рекомбинант ДНХ), 500ОУН нунтаг, кит	1 (өнчин эм)		
7	Гемофилийн эсрэг фактор VIII, (рекомбинант ДНХ), 250ОУН нунтаг, кит	1 (өнчин эм)		
8	Гемофилийн эсрэг фактор IX, рекомбинант ДНХ), 500ОУН нунтаг, кит	1 (өнчин эм)		
9	Гемофилийн эсрэг фактор IX, рекомбинант ДНХ), 250ОУН нунтаг, флакон + 10мл тарианы ус, флакон, кит	1 (өнчин эм)		
10	Гемофилийн эсрэг фактор VIII, (рекомбинант ДНХ), 500ОУН нунтаг, кит	1 (өнчин эм)		
11	Гликлазид, шахмал, 80мг уртагасан үйлдэлтэй шахмал	3	625,600	486,621
12	Декстроз, 5% жин/эзэл тарианы уусмал, 200мл, 250мл, флакон, уут	7	98,779	43,000
13	Диклофенак натри, 100мг шулуун гэдэсний лаа	6	2,346,705	93,002
14	Диклофенак натри, 2.5% жин/эзэл тарианы уусмал, 3мл туншил	18	695,880	197,550
